



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 01

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Дэлгэрцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 2,101,207,77 (хоёр сая нэг зуун нэг мянга хоёр зуун долоон төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, 1,354,111,45 (нэг сая гурван зуун тавин дөрвөн мянга нэг зуун арван нэгэн төгрөг дөчин таван мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй уурын зуухыг хавсралтын дагуу акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Дэлгэрцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал (А.Мөнхбаатар)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үл хөдлөх хөрөнгө акталснаас гарсан материалыг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдан борлуулах, худалдсанаас орсон орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн  
АА тогтоолын хавсралт



Дэлгэрцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн актлах хөрөнгийн мэдээлэл

№	Барилга байгууламжийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалта нд орсон огноо	Ашиглалтын нийт хугацаа / жилээр /	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			хэмжих нэгж	биет хэмжээ							
1	Уурын зуух	Халаалт	м2	50.8	1986.01.01	36	1	2,101,207,77	2,101,207,77	756,096,32	1,354,111,45
<b>Нийт дүн</b>								<b>2,101,207,77</b>	<b>2,101,207,77</b>	<b>756,096,32</b> (долоон зуун тавин зургаан мянга ерэн зургаан төгрөг гучин хоёр мөнгө) төгрөг	<b>1,354,111,45</b> (нэг сая гурван зуун тавин дөрвөн мянга нэг зуун арван нэгэн төгрөг дөчин таван мөнгө) төгрөг